

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛЫН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАР

2020 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 09-ний өдрийн 1/23 тоот албан бичгээр ирүүлсэн захиалгын дагуу Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйл 27.1.2 дахь заалт, Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журмын 2.1-д заасныг үндэслэн Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын Захиргаа, удирдлагын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын мэргэжилтний албан тушаалын сонгон шалгаруулалтын зарыг олон нийтэд мэдээлж байна.

Сонгон шалгаруулалтыг Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-д заасны дагуу зохион байгуулж явуулна.

Нэг. Дараах болзлыг хангасан албан хаагч, иргэн шалгалтад бүртгүүлнэ:

- Монгол Улсын иргэн байх;
- Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй;
- Сэтгэцийн өвчин, эмгэггүй байх;
- Албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг хангасан байх.

Хоёр. Албан тушаалд тавигдах тусгай шаардлага [/энд дарж зөвлөмжтэй танилцана уу/](#)

| | |
|----------------------------------|--|
| Албан тушаалын ангилал, зэрэглэл | Дэс түшмэл, ТЗ-6 |
| Боловсрол | Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй |
| Мэргэжил | Харилцаа холбооны инженер, харилцаа холбооны менежмент, бусад |
| Мэргэшил | Төрийн албаны богино хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх; |
| Туршлага | Туслах түшмэлийн албан тушаалд болон мэргэжлээрээ ажилласан байх |

Гурав. Сонгон шалгаруулалтад бүртгүүлэхэд дараах баримт бичгийг бүрдүүлсэн байна:

“Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 2.3-т заасан дарааллын дагуу нөхнө. Төрийн байгууллагад ажиллаж байгаа албан хаагчид бүртгүүлээгүй тохиолдолд гүйцэтгэх албан тушаалын нөөцөд байгаа иргэд сонгон шалгаруулалтад оролцоно.

- Эрүүл мэндийн асуумж хуудас; [энд дарж татаж авна уу.](#)
- Төрийн албан хаагчийн анкет;
- Шалгалтад бүртгүүлэхээр бичгээр гаргасан хүсэлт;

- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/ Хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;
- Нийгмийн даатгалын дэвтэр /Хөдөлмөрийн дэвтэр/;
- Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичиг;
- 2017-2018 оны төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн илтгэх хуудас, 2019 оны төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ;
- Сүүлийн 12 сарын хугацаанд сахилгын шийтгэл хүлээсэн эсэх талаарх лавлагаа;
- “4 x 6”-гийн хэмжээний цээж зураг;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд холбогдох баримт.

Тайлбар:

Дээр дурдсан баримт бичгийг нотариатаар баталгаажуулсан байхыг заавал шаардахгүй бөгөөд баримт бичгийн үнэн зөвийг иргэн хариуцна.

Хэрвээ хуурамч баримт бичиг бүрдүүлэн төрийн албаны тусгай шалгалтад бүртгүүлсэн, оролцсон, нэр дэвшсэн, албан тушаалд томилогдсон нөхцөлд үүнээс үүдэн гарах хариуцлагыг буруутай этгээд хүлээнэ.

Баримт бичгийн эх хувийг зохих шаардлагад нийцүүлэн цахим хэлбэрээр, тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

Төрийн албан хаагчийн анкет, шалгалтад бүртгүүлэх тухай хүсэлтэд өөрийн гарын үсгээ зурсан байна.

Дөрөв. Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтийг хүлээн авах ба бүртгэх

Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 141 дүгээр тогтоолоор төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалын болон төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах шалгалтыг хялбаршуулсан горимоор шуурхай зохион байгуулахаар шийдвэрлэсэн болно.

Сонгон шалгаруулалтын комисс болон ажлын хэсэг тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад оролцох иргэний хүсэлт, холбогдох баримт бичгийг **2020 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 09:00-17:00** цагийн хооронд quitsetgek@psc.gov.mn хаягаар цахимаар хүлээн авна.

Бүртгүүлэхээр ирүүлсэн иргэний хүсэлт, холбогдох баримт бичгийг тухайн албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг хангаж байгаа эсэхийг комисс нягтлан шалгана.

Холбогдох баримт бичгийг бүрэн бүрдүүлсэн албан хаагч, төрийн жинхэнэ албаны нөөцөд байгаа иргэнийг бүртгэх тухай шийдвэрийг комисс хуралдаанаараа хэлэлцэн гаргах ба болзол хангаагүй бол энэ тухай шалтгааныг мэдэгдэнэ.

Тав. Сонгон шалгаруулалтын хуваарь

Сонгон шалгаруулалтыг **2020 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 14:00 цагт** Засгийн газрын 11-р байрны 1 давхарт “Төрийн албаны зөвлөлийн сургалтын танхим”-д дараах агуулгын хүрээнд зохион байгуулна. Үүнд: ([уншиж судлах эрх зүйн баримт бичгийн жагсаалтыг энд дарж үзнэ үү.](#))

1. Тухайн салбар, албан тушаалд хамаарах хууль, эрх зүйн мэдлэг;
2. Дүн шинжилгээ хийх чадвар
3. Асуудал шийдвэрлэх чадвар;
4. Монгол хэлний ярианы болон бичгийн чадвар;
5. Багаар ажиллах чадвар;
6. Оролцогчдын үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин.

Төрийн албаны шалгалтад оролцох иргэд шалгалт эхлэхээс 15-аас доошгүй минутын өмнө Иргэний үнэмлэхтэйгээ ирж суудлаа эзэлсэн байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Холбоо барих утас: 51264493, 51265544, 51266887